



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 06 сарын 07 өдөр

Дугаар А/48

Улаанбаатар хот

Зочид буудал, дэн буудлын үйл
Ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох,
хүчингүй болгох тухай

Аялал жуулчлалын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь заалт, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам”-ын 5.1, Газрын дүрмийн 2.5.3-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам” болон “Зочид буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS4588:2008” стандартын шаардлагыг хангасан, тушаалын нэгдүгээр хавсралтад дурдсан аж ахуйн нэгжид Зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

2. “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам” болон “Дэн буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS5738:2007” стандартын шаардлагыг хангасан, тушаалын хоёрдугаар хавсралтад дурдсан иргэн, аж ахуйн нэгжид Дэн буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан Гамба ХХК-ийн “Хорека” зочид буудлын 17/122, Тайж өргөө од ХХК-ийн “Тайж” зочид буудлын 17/125, Аргалжирэм ХХК-ийн “Футура” зочид буудлын 17/103, Агнай ХХК-ийн “Сансар” дэн буудлын 17/138, Хавай жим ХХК-ийн “Хавай” дэн буудлын 17/086, Даниста номадс тур ХХК-ийн “Даниста номадс” дэн буудлын 17/015 тоот гэрчилгээг хүчингүй болсонд тооцсугай.

4. Зөвшөөрөл авсан байгууллага болон иргэдтэй гэрээ байгуулж үр дүнг тооцон ажиллахыг Захиргааны хэлтэс /Д.Ганболд/-т үүрэг болгосугай.

1150500162

5. Энэхүү тушаалыг Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, Нийслэлийн Цагдаагийн газар болон дүүргүүдийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэхийг Үйлчилгээний байгууллага, стандарт хариуцсан мэргэжилтэн /Б.Амар/-д үүрэг болгосугай.

6. Гэрчилгээний үнэ болох 5000 /таван мянга/ төгрөгийг байгууллага болон иргэн тус бүрээс хураан, Төрийн сан банкны 100200051053 тоот дансанд төвлөрүүлэн, зөвшөөрлийн гэрчилгээний бичилт, олголтод байнгын хяналт тавьж ажиллахыг Ахлах нягтлан бодогч /Б.Батбаатар/-д даалгасугай.

ДАРГА



Д.БАТСҮХ

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2018 оны 06
сарын 07 өдрийн А/48 дугаар
тушаалын хоёрдугаар хавсралт

ДЭН БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ

2018.06.07

Улаанбаатар хот

| Д/д | Иргэн, аж ахуйн нэгжийн нэр | Эзэмшигчийн регистрийн дугаар | Оноосон нэр | Байршил |
|-----|-----------------------------|-------------------------------|----------------|--|
| 1 | Агнай ХХК | 2113961 | Сансар | БЗД-ийн 1-р хороо Энэбишийн гудамж 13 |
| 2 | Хавай жим ХХК | 5739535 | Хавай | БЗД-ийн 25-р хороо Олзвойн 58а |
| 3 | Даниста номадс тур ХХК | 5460174 | Даниста номадс | БГД-ийн 16-р хороо Орхоны 1-37 |
| 4 | Их өгөө үр ХХК | 6292399 | Тав тух | СХД-ийн 13-р хороо өнөр хороолол 198-7 |
| 5 | Омхэ ХХК | 5277726 | Саруулхан | БЗД-ийн 5-р хороо Монелийн 1-14 |
| 6 | СББББ ЗБН | 2267055 | Оюу | БЗД-ийн 16-р хороо 16-р хороолол Дандарын 10 |

-ooOoo-

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2018 оны 06
сарын 07 өдрийн А/48 дугаар
тушаалын нэгдүгээр хавсралт

ЗОЧИД БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ

2018.06.07

Улаанбаатар хот

| Д/Д | Иргэн, аж ахуйн нэгжийн нэр | Эзэмшигчийн регистрийн дугаар | Оноосон нэр | Байршил |
|-----|-----------------------------|-------------------------------|-------------|--|
| 1 | Гамба ХХК | 2829282 | Хорека | БЗД-ийн 14-р хороо ЭТӨЧ 79 |
| 2 | Тайж өргөө од ХХК | 6313841 | Тайж | БЗД-ийн 7-р хороо Доржийн гудамж 3 |
| 3 | Аргалжирэм ХХК | 2043602 | Футура | БГД-ийн 20-р хороо Москвагийн гудамж 30 |

-ooOoo-